



ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Тэтгэвэр авагч банкаа сонгох ажлыг эхлүүлэх тухай” А/233 тоот тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2010 оны 25 тоот тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх арилжааны банкттай хамтран ажиллах журам”-ын 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн тэтгэвэр авагч тэтгэврээ урьдчилан авах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг. “Тэтгэвэр урьдчилан олгох журам”-ыг нэгдүгээр, “Тэтгэврээ урьдчилан авах хүсэлт”-ийн загварыг хоёрдугаар хавсралтаар, “Тэтгэвэр урьдчилан олгох хуудас”-ын загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан журмын дагуу тэтгэврээ урьдчилан авах иргэдийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх ажлыг 2017 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулахыг аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Тэтгэвэр урьдчилан олгох ажлыг эхлүүлж байгаатай холбогдуулан тэтгэврийн програм хангамжид холбогдох өөрчлөлт оруулж 2017 оны 03 дүгээр сарын 05-ны өдрийн дотор аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв /Г.Хүрэлбаатар/, аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын албадыг мэргэжил, арга зүйгээр ханган, зохион байгуулсан ажлын үр дүнг тооцон ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилт, судалгааны газар /Ц.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.

Дөрөв. Тэтгэвэр урьдчилан олгох ажлын явц, үр дүнг улирал тутамд Газрын даргын зөвлөлд танилцуулахыг Санхүү бүртгэлийн газар /Б.Даваахүү/-т үүрэг болгосугай.

Тав. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга Г.Саранд даалгасугай.


ДАРГА



Д.ЗОРИГТ

1000153

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын
ерөнхий газрын даргын 2017 оны
02 дугаар сарын 24-ны өдрийн
А/35 тоот тушаалын
нэгдүгээр хавсралт



ТЭТГЭВЭР УРЬДЧИЛАН ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан нөхцөл, болзлын дагуу тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэд (Цаашид “тэтгэвэр авагч” гэх)-д нийгмийн болон эрүүл мэндийн хэрэгцээ, шаардлагыг нь хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор тэтгэврийг нь урьдчилан олгоход энэ журмын зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Тэтгэвэр авагч банкаа сонгох ажлыг эхлүүлэх тухай” А/233 тоот тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2010 оны 25 тоот тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх арилжааны банктай хамтран ажиллах журам”-ын 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн энэхүү журмыг боловсруулав.

2.2. Энэхүү журмыг аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсүүд тэтгэвэр урьдчилан олгоход мөрдөж ажиллана.

Гурав. Үндсэн хэсэг

3.1. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага нь тэтгэвэр урьдчилан авах талаар хүсэлт гаргасан иргэний тэтгэврийг хамтран ажиллах гэрээ бүхий үйлчлэгч банк (Цаашид “банк” гэх)-аар дамжуулан жилд нэг удаа урьдчилан олгож болно.

3.2. “Тэтгэвэр урьдчилан олгох” гэж тэтгэвэр авагч тухайн сарын тэтгэврээ авснаас хойш дараа сард олговол зохих тэтгэврийг тэтгэвэр авагчийн хүсэлтийг үндэслэн хугацаанаас нь өмнө олгох харилцааг хэлнэ.

3.3. Урьдчилан олгох тэтгэврийн хэмжээ нь тухайн тэтгэвэр авагчийн 3 хүртэлх сарын тэтгэврийн 50.0 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээс хэтрэхгүй байна.

3.4. Урьдчилан олгох тэтгэврийн хугацааг тухайн тэтгэвэр авагчийн хөдөлмөрийн чадвар алдсан хугацаа, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн хуулиар тогтоосон нас (0-19 нас)-нд хүртэлх хугацаагаар хязгаарлана.

3.5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч) нь дараах шаардлагыг хангасан тэтгэвэр авагчид тэтгэврийг урьдчилан олгохоор шийдвэрлэнэ. Үүнд:

3.5.1. Тэтгэвэр авагч баталсан маягтын дагуу тэтгэврээ урьдчилан авах хүсэлтийг харьяа Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч)-т өөрийн биеэр гаргасан;

3.5.2. Тэтгэвэр авагч тэтгэвэр барьцаалсан зээлгүй байх зэрэг болно.

3.6. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч) тэтгэвэр авагчийн хүсэлт,

тэтгэврийн дэвтрийг үндэслэн “Тэтгэвэр урьдчилан олгох хуудас” (Цаашид “ олгох хуудас” гэх)-ыг 2 хувь үйлдэж дор дурдсанаар баталгаажуулна. Үүнд:

3.6.1. Аймаг, дүүрэгт тэтгэврийн байцаагч олгох хуудсыг үйлдэж Нийгмийн даатгалын үйлчилгээний тасгийн даргаар хянуулан баталгаажуулна.

3.6.2. Тасаг бүхий суманд тэтгэврийн байцаагч олгох хуудсыг үйлдэж тухайн сумын Эрүүл мэнд, нийгмийн даатгалын тасгийн дарга хянан баталгаажуулна.

3.6.3. Суманд аймгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн Нийгмийн даатгалын үйлчилгээний тасгийн даргад мэдэгдэж зөвшөөрөл авснаар сумын нийгмийн даатгалын байцаагч олгох хуудаст гарын үсэг зурж баталгаажуулна.

3.7. Банк нь тэтгэвэр авагчийн тэтгэврийг урьдчилан олгохдоо тэтгэврээс нь хүү, шимтгэл тооцож авахгүй.

3.8. Банк тэтгэврийг урьдчилан олгосон тэмдэглэлийг тухайн тэтгэвэр авагчийн “Тэтгэврийн дэвтэр”-т тэмдэглэнэ.

3.9. Нотариатын итгэмжлэл бүхий иргэнд тэтгэврийг урьдчилан олгохгүй.

3.10. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс нь урьдчилан олгосон тэтгэврийн хэмжээгээр дараа сард олгох тэтгэврээс суутган тооцсон хэмжээгээр тэтгэврийн олголтын файлыг бэлтгэн харилцагч банкинд хүргүүлнэ.

3.11. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс нь тэтгэвэр урьдчилан олгосон тэтгэвэр авагчдын бүртгэл хөтлөн, тооцоо хийж, хяналт тавьж ажиллана.

3.12. Тэтгэвэр урьдчилан олголтын тайланг сар бүр гаргаж, мэдээг Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээний хамт Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэлийн газарт ирүүлнэ.

Дөрөв. Хариуцлага

4.1. Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.



Эрүүл мэнд, нийгмийн даатгалын
ерөнхий газрын даргын 2017 оны
02 дугаар сарын 24-ны өдрийн
А/35 тоот тушаалын
хоёрдугаар хавсралт

Тэтгэврээ урьдчилан авах тухай _____ аймаг (сум), дүүргийн
Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (байцаагч)-т хүсэлт гаргах нь:

12. Ургийн овог:

13. Эцэг /эх/-ийн нэр:

14. Нэр:

15. Регистрийн дугаар:

16. Хүйс: эр эм

17. Тэтгэврийн төрөл:

Тэтгэврийн даатгалын сангаас олгох:

Тахир дутуугийн тэтгэвэр

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

Цэргийн алба хаагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр

Цэргийн алба хаагчийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр

ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох:

Тахир дутуугийн тэтгэвэр

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр

18. Тэтгэврийн дэвтрийн дугаар:

19. Сарын тэтгэврийн хэмжээ:

20. Тэтгэвэр урьдчилан авах сарын дугаар:

21. Урьдчилж авах тэтгэврийн хэмжээ: /мөнгөн дүн үсгээр/

.....

22. Тэтгэвэр авдаг банк:

Банкны нэр	Дансны дугаар
	<input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/> <input type="text"/>

Хүсэлт гаргасан:

Хүсэлт хүлээн авсан:

Нийгмийн даатгалын байцаагч

..... /..... /

(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

..... /..... /

(гарын үсгийн тайлал)

Оршин суугаа хаяг:

Харилцах утасны дугаар:


201 ... оны ... сарын ... - ны өдөр

201 ... оны ... сарын ... - ны өдөр

"Тэтгэвэр урьдчилан олгох журам"-ын 3.3-т заасны дагуутөгрөгийг урьдчилан
олгохоор шийдвэрлэв.

Хянасан: тасгийн дарга: /..... /

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын
ерөнхий газрын даргын 2017 оны
02 дугаар сарын 24-ны өдрийн
А/35 тоот тушаалын
гуравдугаар хавсралт



ТЭТГЭВЭР УРЬДЧИЛАН ОЛГОХ ХУУДАС

.....оны дүгээр сарын-ний өдөр

..... банкны-р тооцооны төвд

..... аймаг /дүүргийн/-р сум /хороо/-ын иргэн

..... регистрийн дугаартай төрлийн, дугаар тэтгэврийн
дэвтэртэй тэтгэвэр авагч овогтой-нд

..... оны дүгээр сарын тэтгэвэр /..... /

төгрөгийг тоот харилцах данснаас урьдчилан олгохыг зөвшөөрөв.

Тэмдэг Үйлдсэн тэтгэврийн байцаагч /..... /

Хянасан тасгийн дарга /..... /

Банкны тэмдэглэл.....

Мөнгө хүлээн авсан тэтгэвэр авагч

Харилцах утасны дугаар.....